

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭРСДЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



Шаамар суман дахь Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн
2016 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа

Ерөнхий дүгнэлт:

Хөрөнгө, бараа материалыг холбогдох тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар бүртгэсэн бөгөөд дотуур байрны хүүхдийн хоолны зардлын нормативыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Сүхбаатар 2017 оны 09 сар

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа</p> <p>Аудитын менежер Б.Батмөнх</p> <p>Аудитор А.Дашбат</p> <p>2017 оны 09 дүгээр сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асуух лавлах зүйл байвал 70362442 дугаарын утсаар холбоо барина уу.</p> <p>ХАЯГ:</p> <p>Сэлэнгэ аймаг Сүхбаатар хот Аймгийн ЗДТГ-ын өргөтгөлийн 2-р давхар</p>	<p>АГУУЛГА</p> <table> <tr> <td>Товчилсон үгийн тайлбар</td> <td>3</td> </tr> <tr> <td>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....</td> <td>4</td> </tr> <tr> <td>Үндсэн мэдээлэл.....</td> <td>5</td> </tr> <tr> <td>Аудитын дүн.....</td> <td>5-17</td> </tr> </table> <p>Бүлэг 1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?</p> <p>1.1 Цалин, НДШ-ийн зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх?</p> <p>1.2 Тогтмол зардлыг бодитой төлөвлөж зарцуулсан уу?</p> <p>1.3 Хичээл үйлдвэрлэлийн дадлага, хоолны зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх?</p> <p>Бүлэг 2. Хөрөнгийн худалдан авалтыг хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэж, үнэн зөв тайлагнасан эсэх?</p> <p>2.1 Хөрөнгийн худалдан авалтыг хууль, журмын дагуу гүйцэтгэсэн үү?</p> <p>2.2 Хөрөнгийн орлого, зарлагыг үнэн зөв бүртгэсэн эсэх?</p> <p>Бүлэг 3. Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, хууль, журмын дагуу зарцуулж, тайлагнаж байна уу?</p> <p>3.1 Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнасан уу?</p> <p>3.2 Өөрийн орлогыг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх?</p> <p>Дүгнэлт..........17</p> <p>Зөвлөмж..........18-19</p> <p>Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Саналд өгсөн тайлбар</p>	Товчилсон үгийн тайлбар	3	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4	Үндсэн мэдээлэл.....	5	Аудитын дүн.....	5-17
Товчилсон үгийн тайлбар	3								
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	4								
Үндсэн мэдээлэл.....	5								
Аудитын дүн.....	5-17								

Товчилсон үгийн тайлбар

ЭА	Эрсдэлийн аудит
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
БСШУ	Боловсрол, соёл шинжлэх ухаан
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТҮМБ	Төрийн үйлчилгээ Мэргэжлийн боловсрол
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын нэр:

Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа.

2. Аудитын код:

СЭА-2017/01/СТА-ЭА

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэв.

4. Аудитын зорилт:

Шаамар суман дахь MCYT-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зарим эрсдэлтэй асуудлыг сонгон шалгаж, дүгнэлт гарган, санал зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад эрсдэлийн аудитын зорилт чиглэгдсэн болно. Эрсдэлийн аудитыг дараах 3 дэд асуудлын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?
2. Хөрөнгийн худалдан авалтыг хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэж, үнэн зөв тайлагнасан эсэх?
3. Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэн, хууль, журмын дагуу зарцуулж, тайлагнаж байна уу?

5. Аудитын хамрах хүрээ:

Шаамар суман дахь MCYT-ийн 2016 оны санхүүгийн зарим үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхийн тулд тус байгууллагын НББ-ийн анхан шатны баримт, санхүүгийн тайлан баланс, худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материал, мэдээллийн эх сурвалжуудыг хамруулав.

6. Аудитын арга зүй:

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Тус MCYT-ийн захирал, нягтлан бодогч, эд хариуцагч нартай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, тус байгууллагаас ирүүлсэн мэдээлэл, нотлох зүйлийг ашиглан түүнд судалгаа, шинжилгээ хийх, давтан шалгах зэрэг арга зүйг ашиглалаа.

7. Үндсэн мэдээлэл

Шаамар суман дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь /цаашид MCYT гэх/ нь анх 1978 онд байгуулагдаж, 2000-2001 оны хичээлийн жилээс шаталсан сургалттай MCYT, 2010 оноос Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болж сургуулийн зэрэглэл, улсын бүртгэлийн гэрчилгээ, мэргэжлийн зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа явуулж байна. Тус MCYT нь “Хөдөө аж ахуйн зах зээлийн эрэлтэд нийцсэн ХАА-н салбарын өндөр чадамжтай, өрсөлдөх чадвартай, бүтээлч хандлага төлөвшөөн мэргэжилтэй ажилтан бэлтгэж, чадамжид сууринсан сургалтын чанартай үйлчилгээ үзүүлнэ” гэсэн эрхэм зорилготойгоор, фермерийн аж ахуй эрхлэгч, авто машины засварчин, тогооч, үсчин, хүнд машин механизмын оператор, зөгийчин, зөгийн аж ахуйн эрхлэгч, няглан бодох бүртгэл, тооцооны ажилтан, мэргэшсэн жолооч, хүнсний ногооны фермер, цэцэрлэгт хүрээлэнгийн цэцэрлэгч, тракторын механик зэрэг мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.

Тус MCYT нь 2016 онд 51 багш, ажиллагсад, 169 суралцагсадтайгаар мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд улсын төсвөөс 752,037.2 мянган төгрөгийн, НДС-гаас 2,355.9 мянган төгрөгийн, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас 11,578.1 мянган төгрөгийн, Дэлхийн зөн ОУБ-аас 1,260.0 мянган төгрөгийн, өөрийн орлогын 14,300.0 мянган төгрөгийн, хөрөнгийн орлогын 63,807.3 мянган төгрөгийн зэрэг нийт 1.200,326.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан байна.

БҮЛЭГ 1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байна уу?

1.1. Цалин, НДШ-ийн зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх

Шаамар суман дахь MCYT-ийн 2016 оны батлагдсан төсвийн 60.6 хувийг цалин хөлс, НДШ-ийн зардал, 18.0 хувийг тогтмол зардал, 14.2 хувийг нормативт зардал, 7.2 хувийг бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байна. Тайлант онд тус MCYT нь удирдах 3, гүйцэтгэх 30, үйлчилгээний 21 нийт 54 орон тоотойгоор сургалтын үйл ажиллаагаа явуулахаар төсөв батлагдаж, гүйцэтгэлээр үндсэн 51 орон тоотойгоор ажиллаж, 4 ерөнхий эрдмийн багш цагаар ажиллуулсан байна. Цалин, НДШ-ийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 / мян.төг/

Д/Д	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Зөрүү
			Дүн	Хувь	
1	Үндсэн цалин	428,204.4	415,859.6	97.1	12,344.8
2	НДШ	47,102.4	45,041.8	95.6	2,060.6
ДҮН		475,306.8	460,901.4	97.0	14,405.4

Тайлант онд цалин, НДШ-ийн зардал 97.0 хувийн гүйцэтгэлтэй буюу 14,405.4 мянган төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан нь статистик мэдээллийн ажилтан, арга зүйчийн орон тоог хавсруулан ажиллуулсантай холбоотой байна.

Засгийн газрын 2014 оны 75 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишиг”-ийг үндэслэн MCYT-ийн захирлын 2016 оны 01-р сарын 04-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар багш нарын үндсэн цалинг ТҮМБ-3-1-ээс ТҮМБ-3-5 шатлалаар, ажиллагсадын цалинг ТҮ-ийн шатлалаар тус тус тогтоожээ.

Хөдөлмөрийн сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Б/41 тушаалаар тушаалаар тус MCYT-ийн захирлын цалинг ТҮМБ-6-3 шатлалаар тогтоосныг мөрдөж ажилласан байна.

Тус MCYT-ийн цалингийн зардлын гүйцэтгэлийн 77.3 хувийг үндсэн цалин, 22.7 хувийг нэмэгдэл цалин эзэлж байгааг дараах хүснэгтээр харуулбал:

2016 оны цалингийн гүйцэтгэлийн бүтэц

Хүснэгт-№2 / мян төг /

Бүтэц	Мөнгөн дүн	Эзлэх хувь
Үндсэн цалин	321,706.0	77.3
Нэмэгдлүүд:Тэргүүлэх зэрэг	689.6	0.2
Заах арга	5,781.7	1.4
Ур чадвар	7,340.8	1.8
Хоолны нэмэгдэл	39,621.4	9.5
Зэргийн нэмэгдэл	442.0	0.1
Илүү цаг	10,583.9	2.5
Ажил хавсарсан	1,317.7	0.3
Анги даалт	727.5	0.2
Цагийн багшийн хөлс	1,644.2	0.4
Багц цаг	14,112.8	3.4

Бусад шагнал, урамшуулал	11,892.0	2.9
Нийт	415,859.6	100

/мян.төг/

Эрсдэлийн аудитын хүрээнд Шаамар суман дахь MCYT-ийн цалингийн зардлын зарцуулалтыг цалингийн баримт, цагийн бүртгэл, холбогдох тушаал шийдвэртэй нь тулган баталгаажуулахад багш нарын багц цаг /кредитийн нэмэгдэл/-ийн нэмэгдлийг тооцох үзүүлэлтэд ордог мэргэжлийн уралдаан тэмцээн, бусад спорт, урлагийн наадамд амжилт үзүүлсэн багш, ажиллнуудад цалингийн хувиар тооцон, **1,133.2** мянган төгрөгийг багц цагийн нэмэгдэлтэй давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Тайлант онд тус MCYT нь 10 багш, ажиллнуудад нийт **7,340.8** мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон боловч үнэлсэн нотлох баримт, шийдвэр байхгүй байгаа нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны албан хааҷид үр чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 2-д “Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэд арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл гоц авьяастай ажилтанд үр чадварын нэмэгдэл олгоно” гэж заасныг зөрчиж байна.

MCYT-ийн захирлын 2014 оны Б/118 тоот тушаалаар унаа, хоолны хөнгөлөлтийг хоногийн 3600 төгрөгөөр тооцож олгохоор баталсны дагуу тайлант онд нийт 39,621.4 мянган төгрөгийн унаа хоолны нэмэгдэл олгосон ч Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 22 дугаар зүйлийн 22.1.4-д заасныг зөрчин **396.2** мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан байна.

Өөр ажлын байранд томилогдсон 1 багшийн үндсэн цалинг хуучин ажлын байрны шатлалаар тооцож **210.8** мянган төгрөгийг илүү олгосон байгаа нь ЗГ-ын 2014 оны 75 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишиг”-ийг зөрчсөн байна.

Цаашид багш, ажиллагсадын үндсэн цалин, нэмэгдлийг тооцож олгоходоо холбогдох тогтоол, журам, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

1.2. Тогтмол зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан уу

2016 онд Шаамар суман дахь MCYT-ийн тогтмол зардалд 141,254.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 141,254.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №3 /мян.төг/

Д/Д	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Зөрүү
			Дүн	Хувь	
1	Гэрэл, цахилгаан	35,666.0	37,460.5	105.0	(1,794.5)
2	Түлш халаалт	105,588.0	103,793.5	98.3	1,794.5
ДҮН		141,254.0	141,254.0	100.0	-

Тус MCYT нь тайлант оны эхний хагаст түлш халаалтын зардалд 50,002.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд “Бурхантын Илч” ХХК, “Тэмлэн харгуй” ХХК-уудаас нийт 556 тн /1тн-г 90.0 мянган төгрөгөөр/ нүүрс худалдан авч зарцуулсан боловч уурын зуухны түлшний норм тодорхойгүй, хэрэглэсэн нүүрсний зарцуулалтын бүртгэл, тайланг тухай бүр үйлдэлгүйгээр сарын эцэст бөөн дүнгээр шаардахаар зарлагадаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Тайлант оны 09 сараас эхлэн он дуустал “Эл Си Би” ХХК-тай гэрээ байгуулан халаалтын зуухны газар, дулааны шугам сүлжээний ажлыг гүйцэтгүүлэн нийт 53,791.3 мянган төгрөгийн халаалтын зардал гаргасан байна.

Халаалтын болон цахилгааны төлбөрийг сар бүр ханган нийлүүлэгчийн нэхэмжлэхийн дагуу хийж гүйцэтгэн, жилийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллажээ.

Тус MCYT нь 2017 оноос нэгдсэн дулаанд холбогдон үйл ажиллагаагаа явуулж байна.

1.3. Хичээл үйлдвэрлэлийн дадлага , хоолны зардлыг бодитой төлөвлөж, зарцуулсан эсэх

Шаамар суман дахь MCYT нь тайлант онд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 17,438.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Гэвч хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас нийт 14,899.3 мянган төгрөгийн сургалтын материал худалдан авсан боловч **12,254.3** мянган төгрөгийн /2,645.0 мянган төгрөгийн шатахууны материалын тайлан гаргасан/ материалыг шууд зардлаар бүртгэж, материалын тайлан гаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2006 оны

388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагаад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Тус MCYT-ийн дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 109,219.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 100,117.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 63,264.6 мянган төгрөгийг зарцуулан, 36,853.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. 2016 оны эхэнд 13,409.4 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 63,264.6 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч, 1,010.9 мянган төгрөгийн мал туслах аж ахуйгаас шилжүүлэн авч, 67,840.8 мянган төгрөгийн материалыг зарцуулан оны эцэст 9,844.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнасан байна.

Шаамар суман дахь MCYT-ийн дотуур байрны хүүхдийн хоолны нормативт зардлын тооцоо

Хүснэгт №4 / мян төг /

Сар	Хүүхдийн тоо	Нэг хүүхдэд ногдох нормативт зардал	Нормативт төсөв	Бодит төсвийн гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт/
1	3652	2315	8,454.4	8,599.7	145.3
2	2240	2315	5,185.6	9,603.5	4,417.9
3	2411	2315	5,581.5	5,953.5	372.0
4	2312	2315	5,352.3	1,466.5	(3,885.8)
5	2443	2315	5,655.5	4,392.7	(1,262.8)
6	840	2315	1,944.6	114.1	(1,830.5)
7		2315	-	15,000.0	15,000.0
8	85	2315	196.8		(196.8)
9	1706	2315	3,949.4		(3,949.4)
10	2320	2315	5,370.8	8,474.0	3,103.2
11	2213	2315	5,123.1	8,950.0	3,826.9
12	2535	2315	5,868.5	710.6	(5,157.9)
Нийт дүн	22757		52,682.5	63,264.6	10,582.1

Дээрх түүврээс харахад тус MCYT нь тайлант онд дотуур байрны 22757 хүүхдийн хоолны зардалд 63,264.6 мянган төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 тоот тогтоолоор баталсан нормативт зардлыг **10,582.1** мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Тус сургуульд суралцсан хүүхдийн тоо, дотуур байрны хүүхдийн тоог сүүлийн 5 жилээр харуулбал:

Хүснэгт №5

Хичээлийн жил	Суралцагсдын тоо	Өсөлт бууралтын тоо	Хувь	Дотуур байрны хүүхдийн тоо	Өсөлт бууралтын тоо	Хувь
2012-2013	366	81	28.4%	193	6	3.2%
2013-2014	255	-111	-30.3%	162	-31	-16.1%
2014-2015	256	1	0.4%	185	23	14.2%
2015-2016	221	-35	-13.7%	151	-34	-18.4%
2016-2017	169	-52	-23.5%	134	-17	-11.3%

Дээрх үзүүлэлтээс харахад тус МСҮТ-ийн суралцагчдын тоо сүүлийн жилүүдэд 13.7-30.3 хувиар, дотуур байрны хүүхдийн тоо 11.3-18.4 хувиар тус тус буурсан харагдаж байгаа бөгөөд энэ нь оюутнуудад тэтгэлэг олгохоо больсонтой холбоотой байх талтай. Хоолны зардлыг төлөвлөхдөө дотуур байрны хүүхдийн тооны өмнөх жилүүдийн гүйцэтгэл, бусад хүчин зүйлтэй уялдуулж үндэслэлтэй тооцоолохгүй байгаагаас бодит байдлаас өндөрөөр батлуулсан байна.

Тайлант онд цалин, НДШ-ийн 91,060.0 мянган төгрөгийн, халаалтын 53,791.3 мянган төгрөгийн, бичиг хэргийн 659.0 мянган төгрөгийн, БҮТЭЗ-ийн 291.3 мянган төгрөгийн, эмний 400.0 мянган төгрөгийн, нормын хувцас, зөвлөн эдлэлийн 255.6 мянган төгрөгийн, урсгал засварын 591.1 мянган төгрөгийн, томилолтын 4,136.8 мянган төгрөгийн, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох 1,500.0 мянган төгрөгийн, хичээл үйлдвэрлэлийн дадлагын 14,131.7 мянган төгрөгийн зэрэг нийт **166,816.8** мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөөт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Цаашид хоолны зардлыг нэг хүүхдэд ногдох нормативыг баримтлан бодитой төлөвлөх, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас худалдан авсан хөрөнгийг материалын дансанд орлого авч зарцуулах, ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. Хөрөнгийн худалдан авалтыг хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэж, үнэн зөв тайлагнасан эсэх?

2.1 Хөрөнгийн худалдан авалтыг хуулийн дагуу гүйцэтгэсэн эсэх

Тайлант онд тус MCYT нь Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар хичээл сургалтад шаардлагатай “E-TVET сургалтын цахим програм”-ыг 14,500.0 мянган төгрөгөөр худалдан авсан бөгөөд сонгон шалгаруулалт нь харьяа яаман дээр зохион байгуулагдсан байна.

Тус MCYT нь өөрийн уурын зуухаар халаадаг бөгөөд тайлант онд 109,219.0 мянган төгрөгийн халаалтын төсөв батлагдсан ч хагас жилийн төсвөөр тооцож нүүрсний худалдан авалтыг нээлттэй тендерээр бус харьцуулалтын аргаар гүйцэтгэж, “Бурхантын илч” ХХК-ийг сонгон шалгаруулсан, 40,012.2 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан байна. Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Захирлын 2016.01.04-ний өдрийн А/02 тоот тушаалаар тендер сонгон шалгаруулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг нь тендер шалгаруулалтад тавигдах шалгуур үзүүлэлт, шаардлагыг тусгасан тендерийн баримт бичиг боловсруулж, түүний дагуу үнэлж шалгаруулаагүй байгаа нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 12.2-д “Захиалагч тухайн тендер шалгаруулалтанд тавигдах чадавхийн шалгуур үзүүлэлт, шаардлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд нийцүүлэн тогтоож, тендерийн баримт бичигт тусгана” гэсэн заалтыг зөрчжээ гэж дүгнэж байна.

Хөдөлмөрийн яамнаас “2016 оны батлагдсан төсөөвтөө багтаан халаалтын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх” гэсэн албан бичгийн дагуу тайлант оны 9-12 сард халаалтын зуухны газар, дулааны шугам шүлжээний ажлыг “Эл Си Би” ХХК-тай гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, 53,791.3 мянган төгрөг шилжүүлсэн байна. Гэвч сонгон шалгаруулалтыг явуулахдаа тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2013 оны 125 дугаар тушаалаар батлагдсан зааврын дагуу боловсруулалгүйгээр захирлын зөвлөлөөр хэлэлцэж, гүйцэтгэгчийг бүх багш, ажилчдын хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Тендерт оролцох саналыг “Эл Си Би” ХХК, “Мон жим трейд” ХХК, “Албанбилэг” ХХК-д хүргүүлснээс “Эл Си Би” ХХК материал ирүүлж, бусад 2 компани татгалзсан хариу өгснөөр тус компанийг шалгаруулж, хамтарч ажиллах гэрээ байгуулсан байна.

2 тал тус гэрээний 5 дугаар зүйлийн 5.5-д “Гэрээлэгч нь А талын 8 галч, 1 механикыг ажлын байраар хангаж, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшилүүлэх, тэдний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангана. Ажиллагсдын хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгохтой холбоотой асуудлыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ”, 5.6-д “Ажилчдын цалинг одоо авч буй хэмжээнээс бууруулахгүйгээр батлагдсан орон тооны дагуу А талын санал болгосноор орон нутгаас авч ажиллуулан нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, орлогын албан татварыг орон нутгийн татварын албанад төлнө” гэж заасныг тус тус зөрчиж, МСҮТ-ийн төсвөөс 7 галч, 1 механикт тайлант оны 9-12 сард нийт **17,784.4** мянган төгрөгийн цалин олгосон байна.

Цалингийн тооцооллыг задалж харуулбал:

Хүснэгт №6 / мян төг /

№	Нэр	Албан тушаал	Сар				Дүн
			9	10	11	12	
1	Г.Болдбаяр	Галч	467.5	610.0	463.9	547.1	2,088.5
2	Ц.Мөнхбат	Галч	495.2	648.7	491.6	580.8	2,216.3
3	О.Наранбат	Галч	515.2	573.3	605.0	605.0	2,298.5
4	Т.Батцэнгэл	Галч	470.3	613.9	550.5	466.7	2,101.4
5	М.Сонинбаяр	Галч	470.3	613.9	550.5	584.0	2,218.7
6	Ч.Батбаяр	Галч	467.5	518.0	547.1	547.1	2,079.7
7	Ч.Отгонжаргал	Галч	467.5	610.0	463.9	547.1	2,088.5
8	Ж.Дориунхүү	Механик	659.6	648.8	728.1	656.0	2,692.5
Нийт дүн			4,013.1	4,836.6	4,400.6	4,533.8	17,784.1

Харин дотуур байрны хоолны материалын сонгон шалгаруулалтыг аймгийн Худалдан авах ажиллагааны албаар гүйцэтгүүлж, шалгарсан “Хөтөл төвхөн” ХХК-тай гэрээ байгуулан, 33,134.6 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна. Сонгон шалгаруулалт 4-6 саруудад зохион байгуулагдаж байгаагаас гүйцэтгэгч шалгартал 30,129.9 мянган төгрөгийн хүнсний материалыг шалгуур үзүүлэлт, чанарын баталгаа тодорхойгүй олон тооны дэлгүүрээс худалдан авсан байна.

Цаашид худалдан авах ажиллагааны үе шат бүрийг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэхээс гадна дараа оны гүйцэтгэгчийг өмнөх онд нь сонгон шалгаруулж байх нь зүйтэй юм.

2.2 Хөрөнгийн орлого, зарлага, хөдлөл өөрчлөлтийг үнэн зөв бүртгэсэн үү?

Шаамар суман дахь МСҮТ нь 2016 оны эхэнд 7,458,657.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бол төсвийн хөрөнгөөр 14,500.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар 2,850.0 мянган төгрөгийн, Хөдөлмөрийн яамнаас шилжүүлсэн 55,269.5 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 2016 оны 195 тоот тогтоолоор 47,223.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлан, 4,435,987.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг байгуулж, оны эцэст 3,048,066.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр тайлагнагдсан байна.

Хөдөлмөрийн яамнаас 55,269.5 мянган төгрөгийн өртөгтэй компьютер, тоног төхөөрөмж, Дэлхийн зөн ОУБайгууллагаас бэлэглэлийн гэрээгээр 3,826.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд орлого авч бүртгэсэн байна.

Эрсдэлийн аудитын явцад газар дээр нь очиж үндсэн хөрөнгийг бүртгэлтэй нь тулган шалгахад хүнд машин механизмын анgid хэрэглэгддэг, 2011 онд ашиглалтад орсон 86,226.0 мянган төгрөгийн өртөгтэй “Универсаль трактор”-ын апартур эвдэрсний улмаас ашиглагдах боломжгүй байна.

Тракторын сэлбэг өндөр үнэтэй байдаг, яамнаас төсөв тавьж өгдөггүй гэсэн шалтгаанаар өндөр өртгөөр худалдан авсан уг тоног төхөөрөмжийг ашиглахгүй байгаа нь төрийн өмч хөрөнгө, төсвийн хөрөнгийн үр өгөөж, үнэ цэнийг бууруулж, цаашилбал суралцагсад, төгсөгчдийн мэргэжлийн чанарт ч нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна гэж дүгнэж байна.

Зураг 1. 86,226.0 мянган төгрөгийн өртөг бүхий ашиглагдахгүй байгаа трактор



НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2.1- □ “Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн, МСҮТ-ийн захирлын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалаар тооллогын комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон гүйцэтгүүлж, хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг данс бүртгэлд бүрэн тусгаж, үлдэгдлийг баталгаажуулсан байна.

МСҮТ-ийн захирлын 2016 оны 05-р сарын 30-ны өдрийн А/17 тоот тушаалаар байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан байна.

Тайлант онд Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр байгууллагын дотоод журмын 7.4.3.7 дахь заалтыг үндэслэн багш, ажилчдад туслах аж ахуйгаас 23 хонь, 18 ямааг буцалтгүйгээр олгосон байна. Гэвч бараа материалын данснаас зарлага гаргахдаа **140.0** мянган төгрөгийн өртөгтэй 2 шүдлэн хонь илүү зарлагадсан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Тус МСҮТ нь тайлант оны эхэнд 61,084.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бол төсвийн хөрөнгөөр 87,071.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Дэлхийн зөн ОУБ-аас 976.9 мянган төгрөгийн материал, туслах аж ахуйгаас 1,010.9 мянган төгрөгийн мал шилжүүлэн авч, 138,398.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 2,410.0 мянган төгрөгийн малыг хасалт хийж нас дэвшүүлэн, 9,301.5 мянган төгрөгийн материалыг акталж, 53,735.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Гэвч тайлант онд бичиг хэргийн зардлаас 1,407.7 мянган төгрөгийн, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс авах зардлаас 1,218.3 мянган төгрөгийн, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 295.0 мянган төгрөгийн, нийт **2,921.0** мянган төгрөгийн материал худалдаж авсан боловч бараа материалын дансанд орлого, зарлагаар тайлагнаагүй, зарцуулалт нь тодорхойгүй, мөн шатахууны данснаас **2,165.8** мянган төгрөгийн материалыг зарлагадахдаа шаардах хуудасгүйгээр шууд зарлагадсан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт

хийж баталгаажуулна”, 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Мөн бараа материалын дансанд 9,028.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,359.9 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, нийт **12,388.4** мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөөт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө” стандартын 13 (а), (б) заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Цаашид үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл хөтлөлтийг холбогдох хууль, журмын дагуу бүртгэж, тайлагнаж байх шаардлагатай байна.

Бүлэг 3. Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, хууль, журмын дагуу зарцуулж, тайлагнасан эсэх?

3.1 Өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж, санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнасан эсэх?

Тус MCYT нь 2016 онд үндсэн үйл ажиллагаанаас 4,800.0 мянган төгрөгийн, туслах үйл ажиллагаанаас 4,600.0 мянган төгрөгийн, нийт 9,400.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс үндсэн үйл ажиллагаагаар 4,410.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагаагаар 9,890.0 мянган төгрөг, нийт 14,300.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 52.1 хувиар орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. Тайлант онд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг дараах эх үүсвэрээс төвлөрүүлсэн байна. Тодруулбал:

- ❖ Юнителийн түрээсээс 2,700.0 мянган төгрөгийн;
- ❖ Скайтелийн түрээсээс 1,350.0 мянган төгрөгийн;
- ❖ Дотуур байранд оршин суудаг багш нарын түрээсээс 7,828.0 мянган төгрөгийн;
- ❖ Дэлхийн зөн ОУБ түрээсээс 1,260.0 мянган төгрөгийн;
- ❖ Худаг ажиллуулсны усны орлого 1,162.0 мянган төгрөгийн орлого тус тус бүрдүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланда тайлагнасан байна.

Тус MCYT-ийн авто засварын ангийн оюутнуудын дадлагын ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэн ажлын хөлсний тодорхой хувийг өөрийн орлогод төвлөрүүлэх замаар үндсэн үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх, ХАА-н фермерийн ангийн оюутнуудын дадлагын ажлаас сүү, сүүн бүтээгдэхүүн, төрөл бүрийн хүнсний ногоонуудыг

боловсруулан дотуур байрны хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх замаар туслах үйл ажиллагааны орлогыг бий болгох бүрэн боломжтой байна. Гэтэл тус MCYT нь тайлант онд хичээл, сургалт үйлвэрлэлийн дадлагын зардалд 17,428.5 мянган төгрөгийг зарцуулсан ч ямар ч орлого төвлөрүүлээгүй байна.

Иймээс дотоод нөөц боломжийг бүрэн ашиглан, өөрийн орлогыг нэмэгдүүлэн ажиллах шаардлагатай байна.

3.2 Өөрийн орлогыг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан байна уу?

Тус MCYT нь 2016 онд 14,300.0 мянган төгрөгийн өөрийн орлого төвлөрүүлснөөс баталсан төлөвлөгөөний дагуу 9,400.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулж, давсан орлого 4,900.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Эрсдэлийн аудитаар дараах зөрчилд илэрч акт, албан шаардлага бичигдлээ.

Үүнд:

Нэг. Төлбөрийн акт

- ❖ Θөр ажилд томилогдсон 1 багшийн үндсэн цалинг хуучин шатлалаар бодож **210.8** мянган төгрөгийн цалин илүү олгосон зөрчилд төлбөрийн акт бичигдлээ.

Хоёр. Албан шаардлага

- ❖ Багш нарын багц цагийн нэмэгдлийг тооцох үзүүлэлтэд ордог мэргэжлийн уралдаан тэмцээн, бусад спорт, урлагийн наадамд үзүүлсэн амжилтуудад цалингийн хувиар бодож, давхардуулан олгосон 1,133.2 мянган төгрөгийн;
- ❖ Ур чадварын нэмэгдлийг тодорхой шалгуур үзүүлэлт, нотлох баримтгүйгээр шууд олгосон 7,340.8 мянган төгрөгийн;
- ❖ Хичээл үйлдвэрлэлийн дадлагын болон бусад бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардлаар тайлагнасан 15,175.3 мянган төгрөгийн;
- ❖ Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 тоот тогтоолоор баталсан нэг хүүхдэд ногдох нормативаас хэтрүүлсэн 10,582.1 мянган төгрөгийн;
- ❖ Нүүрс нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг нь тендер шалгаруулалтанд тавигдах шалгуур үзүүлэлт, шаардлагыг тусгасан тендерийн баримт бичиг боловсруулж, түүний дагуу үнэлж шалгаруулаагүй;

- ❖ Бараа материалын дансанд нийт 12,388.4 мянган төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил бүртгэсэн зэрэг нийт **46,619.8** мянган төгрөгийн алдаа зөрчилд зөрчил арилгах албан шаардлага бичигдлээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. Амжилт үзүүлсэн багш нарт багц цагийн нэмэгдэлтэй давхардуулан урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.
2. Ур чадварын нэмэгдлийг тодорхой шалгуур үзүүлэлт, нотлох баримтгүйгээр шууд олгосон байна.
3. Багш, ажилчдын унаа, хоолны нэмэгдлээс ХХОАТ-ыг дутуу суутгасан байна.
4. Уурын зуухны түлшний норм тодорхойгүйгээс хэрэглэсэн нүүрсний зарцуулалтын тайлан, бүртгэлийг тухай бүр хөтлөлгүйгээр сарын эцэст бөөн дүнгээр зарлагадсан байна.
5. Хичээл үйлдвэрлэлийн дадлагын болон бусад бараа материалыг нярвын тайланд тусгалгүйгээр шууд зардлаар тайлагнасан байна.
6. Дотуур байрны хүүхдийн хоолын зардлыг Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 тоот тогтоолоор баталсан нэг хүүхдэд ногдох нормативаас хэтрүүлсэн байна.
7. Тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа холбогдох хууль, тогтоомж, журмыг зөрчсөн байна.
8. Нүүрс нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг нь тендер шалгаруулалтад тавигдах шалгуур үзүүлэлт, шаардлагыг тусгасан тендерийн баримт бичиг боловсруулж, түүний дагуу үнэлж шалгаруулаагүй байна.
9. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажиллаагүй байна.
10. Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн байна.
11. Төлөвлөгөөт өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлж байгаа ч түүнийг нэмэгдүүлж болох дотоод нөөц бололцоог ашиглаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

MCYT-ийн захирал Б.Хишигжаргалд:

- ❖ Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж ажиллах.

- ❖ Ур чадварын нэмэгдлийг олгоходо холбогдох хууль, журмын дагуу тодорхой үр дүнгийн үнэлгээ, шийдвэр дээр үндэслэж байх.
- ❖ Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулах.
- ❖ Дотуур байрны хүүхдийн хоолны зарцуулалтад Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 тоот тогтоолоор баталсан нэг хүүхдэд ногдох нормативыг мөрдөж ажиллах.
- ❖ Өөрийн орлогыг бодитоор төлөвлөж, дотоод нөөц бололцоогоо ашиглах замаар орлогоо нэмэгдүүлж ажиллах.
- ❖ Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж, алдаа зөрчилгүй ажиллах.

Нягтлан бодогч А.Одонцэцэгт:

- ❖ ХХОАТ-ын тухай хуулийн дагуу багш ажилчдад олгож байгаа унаа, хоолны нэмэгдлээс ХХОАТ-ын суутгалыг бүрэн суутгаж ажиллах.
- ❖ MCYT-ийн багш нарын багц цагийн болон ур чадварын нэмэгдлийг холбогдох шийдвэр, нотлох баримтыг үндэслэж тооцож олгох.
- ❖ Бараа материалыг орлого, зарлагыг бүртгэлд тусгалгүйгээр шууд зардлаар тайлагнадаг явдлыг таслан зогсоож, нярвын тайланг хянан баталгаажуулж ажиллах.
- ❖ Худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу зохион байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.
- ❖ Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөөт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-г мөрдөж ажиллах.
- ❖ Батлагдсан төсөв, санхүү, хөрөнгө мөнгөний зарцуулалтад НББ-ээр тавих хяналтыг сайжруулах.